СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СЭА-2022/256/НА-СТА-ТШЗ



| | | |
|---|---|---|
| | Дарга, тэргүүлэх аудитор: | Ч.Энхтуяа |
| | Утас:7036-3040 | Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn |
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn | Аудитын менежер: | Б.Батмөнх |
| | Утас: 7036-3036 | Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn |
| Сүхбаатар сум | Аудитор: | Т.Мөнхзул |
| 2022 он | Утас: 7036-2442 | Цахим хаяг: Munkhzult@audit.gov.com |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал, дүгнэлт 3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 5-12
3. Аудитын тайлан 13
   3.1. Ерөнхий зүйл 13
   3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 13
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 14
   3.4. Материаллаг байдал 14
   3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга 15
   3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 16
   3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 17
   3.8. Аудитын гол асуудал 17
   3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 17
   3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 17
   3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал 18
4. Аудитын илрүүлэлт 19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 20


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022-02-23 № СТА-2022/256-НА-СТА-ТШЗ

танай ______ -ны № ______ -т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Д.ГАН-ОТГОН ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 23 өдөр Дугаар 11/А1870163 СТА-2022/856-ИД-СТА-743 Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өмнөх оны аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргаж, "Шилэн дансны цахим хуудас"-т мэдээлбэл зохих 149 мэдээллээс 19 мэдээллийг хугацаа хоцроосон,
- Тайлант оны үйл ажиллагаанд 201,782.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 200,322.2 мянган төгрөгийг зарцуулан, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувиар бус 0.7 хувиар хэмнэсэн байна.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.4, 6.10, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх *".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах"* заалтуудыг *тус тус* зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох"* журмын 4.2.1-д *"Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.* 4.2.1.10: *"Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11: "хууль тогтоомж,гэрээ хэлцэл зөрчсөн..."* гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлүүдийг давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид холбогдох хууль, тогтоомж болон аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллахыг Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга Д.Ган-Отгон, нягтлан бодогч Т.Сэлэнгэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

АУДИТОР Т.МӨНХЗУЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,864,503.00** | **10,342,033.00** |
| **33** | **АВЛАГА** | **669,000.00** | **709,300.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 669,000.00 | 709,300.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **7,195,503.00** | **9,632,733.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | **343,076.00** | **549,376.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 343,076.00 | 549,376.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **6,852,427.00** | **9,083,357.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 535,555.00 | 899,555.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,422,869.00 | 7,132,369.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 894,003.00 | 1,051,433.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,348,405.03** | **35,542,206.70** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **33,348,405.03** | **35,542,206.70** |
| 39100 | Газар | 0 | 0 |
| **39200** | **Биет хөрөнгө** | **32,965,605.03** | **35,278,206.70** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 11,418,795.00 | 11,418,795.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -593,717.76 | -879,187.68 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -2,968,750.00 | -4,843,750.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 84,604,600.00 | 91,954,600.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -76,011,491.99 | -78,501,226.63 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,508,734.00 | 6,508,734.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -5,508,564.22 | -5,895,757.99 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 516,000.00 | 516,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **382,800.00** | **264,000.00** |
| 39301 | Программ хангамж | 792,000.00 | 792,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -409,200.00 | -528,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **41,212,908.03** | **45,884,239.70** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **215,277.00** | **0** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **215,277.00** | **0** |
| **41300** | **Өглөг** | **215,277.00** | **0** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 215,277.00 | 0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **40,997,631.03** | **45,884,239.70** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **40,997,631.03** | **45,884,239.70** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 114,990,139.00 | 114,990,139.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-77,491,576.63** | **-72,604,967.96** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -72,704,027.80 | -77,491,576.63 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -4,787,548.83 | 4,886,608.67 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | 0 | 0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,499,068.66 | 3,499,068.66 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **41,212,908.03** | **45,884,239.70** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **181,087,650.00** | **207,801,634.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **81,494,050.00** | **77,039,134.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **81,494,050.00** | **77,039,134.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **81,494,050.00** | **77,039,134.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 80,714,050.00 | 75,942,134.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 780,000.00 | 1,097,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **99,593,600.00** | **130,762,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **99,593,600.00** | **130,302,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 99,593,600.00 | 130,302,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0** | **460,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 460,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **185,875,198.83** | **202,915,025.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **185,875,198.83** | **202,915,025.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **174,123,809.30** | **175,301,546.96** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **118,044,917.92** | **117,802,079.79** |
| 210101 | Үндсэн цалин | 83,335,525.93 | 84,909,028.09 |
| 210102 | Нэмэгдэл | 32,102,028.99 | 28,248,551.70 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,607,363.00 | 4,644,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,712,623.55** | **15,293,013.74** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,959,426.27 | 10,581,040.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,188,299.56 | 1,177,993.29 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 950,599.46 | 942,394.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 237,699.13 | 235,598.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,376,599.13 | 2,355,986.53 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **17,334,719.00** | **16,179,116.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,147,594.00 | 1,486,443.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,643,652.00 | 5,633,653.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 451,473.00 | 659,020.00 |
| 210304 | Байрны түрээс | 10,092,000.00 | 8,400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,082,510.00** | **7,560,031.10** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,578,960.00 | 692,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,490,547.00 | 3,617,570.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,049,653.00 | 1,997,721.10 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,200.00 | 85,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 893,150.00 | 1,166,150.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,110,000.00** | **820,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,110,000.00 | 820,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 0 | 0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,008,920.00** | **979,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 192,500.00 | 0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 95,000.00 | 105,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,721,420.00 | 874,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,950,300.00** | **6,673,200.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,950,300.00 | 6,673,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,143,464.00** | **1,218,408.00** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49,500.00 | 49,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 43,964.00 | 55,948.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0 | 5,160.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,028,000.00 | 1,085,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,736,354.83** | **8,776,198.33** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,081,580.00 | 2,140,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0 | 1,480,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 6,654,774.83 | 5,156,198.33 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,751,389.53** | **27,613,478.37** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **450,000.00** | **21,731,400.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0 | 20,911,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 450,000.00 | 820,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **11,301,389.53** | **5,882,078.37** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,301,389.53 | 5,882,078.37 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-4,787,548.83** | **4,886,608.67** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-4,787,548.83** | **4,886,608.67** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **114,990,139.00** | **3,499,068.66** | **-72,704,027.80** | **45,785,179.86** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **114,990,139.00** | **3,499,068.66** | **-72,704,027.80** | **45,785,179.86** |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | **0** | **0** | **-4,787,548.83** | **-4,787,548.83** |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **114,990,139.00** | **3,499,068.66** | **-77,491,576.63** | **40,997,631.03** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **114,990,139.00** | **3,499,068.66** | **-77,491,576.63** | **40,997,631.03** |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **114,990,139.00** | **3,499,068.66** | **-77,491,576.63** | **40,997,631.03** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 4,886,608.67 | 4,886,608.67 |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **114,990,139.00** | **3,499,068.66** | **-72,604,967.96** | **45,884,239.70** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **182,730,350.00** | **206,664,334.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **83,136,750.00** | **75,901,834.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **83,136,750.00** | **75,901,834.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **83,136,750.00** | **75,901,834.00** |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 83,136,750.00 | 75,901,834.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **99,593,600.00** | **130,762,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **99,593,600.00** | **130,302,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 99,593,600.00 | 130,302,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0** | **460,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 460,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **181,930,350.00** | **199,314,334.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **181,930,350.00** | **199,314,334.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **170,178,960.47** | **171,700,855.63** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **117,848,567.92** | **118,017,356.79** |
| 210101 | Үндсэн цалин | 83,139,175.93 | 80,430,267.32 |
| 210102 | Нэмэгдэл | 32,102,028.99 | 32,942,589.47 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,607,363.00 | 4,644,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,853,696.55** | **15,293,013.74** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,100,499.27 | 10,581,040.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,188,299.56 | 1,177,993.29 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 950,599.46 | 942,394.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 237,699.13 | 235,598.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,376,599.13 | 2,355,986.53 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **17,334,719.00** | **16,179,116.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,147,594.00 | 1,486,443.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,643,652.00 | 5,633,653.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 451,473.00 | 659,020.00 |
| 210304 | Байрны түрээс | 10,092,000.00 | 8,400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,749,293.00** | **9,216,461.10** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,244,890.00 | 1,031,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,384,550.00 | 3,775,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,049,653.00 | 1,997,721.10 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,200.00 | 85,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 2,326,150.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,820,000.00** | **820,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,000,000.00 | 820,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 0 | 0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 820,000.00 | 0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,951,920.00** | **1,461,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,192,500.00 | 0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 800,000.00 | 660,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,959,420.00 | 801,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,950,300.00** | **6,673,200.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 0 | 0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,950,300.00 | 6,673,200.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 0 | 0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **145,464.00** | **420,708.00** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49,500.00 | 49,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 43,964.00 | 55,948.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0 | 5,160.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 30,000.00 | 288,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,525,000.00** | **3,620,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,025,000.00 | 2,140,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 1,480,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,751,389.53** | **27,613,478.37** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **450,000.00** | **21,731,400.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0 | 20,911,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 450,000.00 | 820,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **11,301,389.53** | **5,882,078.37** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,301,389.53 | 5,882,078.37 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **800,000.00** | **7,350,000.00** |
| V | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **800,000.00** | **7,350,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **800,000.00** | **7,350,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **800,000.00** | **7,350,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 800,000.00 | 7,350,000.00 |
| VI | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-800,000.00** | **-7,350,000.00** |
| VIII | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0** | **0** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 201,782,500.00 | 200,322,255.63 | 1,460,244.37 | 99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 201,782,500.00 | 200,322,255.63 | 1,460,244.37 | 99 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 180,511,100.00 | 179,050,855.63 | 1,460,244.37 | 99 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 118,020,200.00 | 118,017,356.79 | 2,843.21 | 100 |
| 210101 | Үндсэн цалин | 82,357,600.00 | 80,430,267.32 | 1,927,332.68 | 97 |
| 210102 | Нэмэгдэл | 32,544,100.00 | 32,942,589.47 | (398,489.47) | 101 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 3,118,500.00 | 4,644,500.00 | (1,526,000.00) | 148 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 15,527,700.00 | 15,293,013.74 | 234,686.26 | 98 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,926,900.00 | 10,581,040.54 | 345,859.46 | 96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,150,200.00 | 1,177,993.29 | (27,793.29) | 102 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 920,200.00 | 942,394.59 | (22,194.59) | 102 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 230,000.00 | 235,598.79 | (5,598.79) | 102 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,300,400.00 | 2,355,986.53 | (55,586.53) | 102 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 17,201,500.00 | 16,179,116.00 | 1,022,384.00 | 94 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 1,560,000.00 | 1,486,443.00 | 73,557.00 | 95 |
| 210302 | Түлш, халаалт | 6,081,800.00 | 5,633,653.00 | 448,147.00 | 92 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 693,400.00 | 659,020.00 | 34,380.00 | 95 |
| 210304 | Байрны түрээс | 8,866,300.00 | 8,400,000.00 | 466,300.00 | 94 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,216,500.00 | 9,216,461.10 | 38.90 | 100 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,232,400.00 | 1,031,790.00 | 200,610.00 | 83 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210402 | Тээвэр (шатахуун) | 3,618,100.00 | 3,775,000.00 | (156,900.00) | 104 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 1,775,500.00 | 1,997,721.10 | (222,221.10) | 112. |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 254,600.00 | 85,800.00 | 168,800.00 | 33 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 2,335,900.00 | 2,326,150.00 | 9,750.00 | 99 |
| 2105 | Нормативт зардал | 820,000.00 | 820,000.00 | - | 100 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 820,000.00 | 820,000.00 | - | 100 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 8,826,400.00 | 8,811,000.00 | 15,400.00 | 99 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,350,400.00 | 7,350,000.00 | 400.00 | 99 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 660,000.00 | 660,000.00 | - | 100 |
| 210604 | Урсгал засвар | 816,000.00 | 801,000.00 | 15,000.00 | 98 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,680,000.00 | 6,673,200.00 | 6,800.00 | 99 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,680,000.00 | 6,673,200.00 | 6,800.00 | 99 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 598,800.00 | 420,708.00 | 178,092.00 | 70 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 48,000.00 | - | 48,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 75,200.00 | 49,500.00 | 25,700.00 | 65 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 72,000.00 | 55,948.00 | 16,052.00 | 77 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 24,000.00 | 22,000.00 | 2,000.00 | 91 |
| 210807 | Газрын төлбөр | 10,000.00 | 5,160.00 | 4,840.00 | 51 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 29,600.00 | - | 29,600.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 340,000.00 | 288,100.00 | 51,900.00 | 84 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,620,000.00 | 3,620,000.00 | - | 100 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,140,000.00 | 2,140,000.00 | - | 100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,480,000.00 | 1,480,000.00 | - | 100 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 21,271,400.00 | 21,271,400.00 | - | 100 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,271,400.00 | 21,271,400.00 | - | 100 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,911,400.00 | 20,911,400.00 | - | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 360,000.00 | 360,000.00 | - | 100. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 201,782,500.00 | 206,204,334.00 | (4,421,834.00) | 102 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 130,302,500.00 | 130,302,500.00 | - | 100 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 130,302,500.00 | 130,302,500.00 | - | 100 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 71,480,000.00 | 75,901,834.00 | (4,421,834.00) | 106 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 71,480,000.00 | 75,901,834.00 | (4,421,834.00) | 106 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5.00 | 5.00 | - | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 3.00 | - | 100 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 460,000.00 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 460,000.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 460,000.00 |
| Бусад урсгал шилжүүлэг | 460,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 460,000.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 460,000.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 460,000.00 |
| ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 460,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн */цаашид Стандарт хэмжилзүйн хэлтэс гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон төлбөрийн цахим баримттай холбоотой 2 зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Стандарт хэмжилзүйн хэлтсийн эрхэм зорилго нь *"Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн төрийн бодлогыг хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцүүлэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хөнгөн шуурхай хүргэх"* –д оршино.

Стандарт хэмжилзүйн хэлтэс нь баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа үзүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" шинэчлэгдсэн,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус хэлтсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Стандарт, хэмжилзүйн газраас томилогдсон ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сард тус хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд хяналт, шалгалт хийж, бүртгэл тайлагналтай холбоотой 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт,хэмжилзүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны зардлыг бодитоор харуулдаг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 185,875.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,788.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 2.091.0 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,671.3 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 669.0 | 709.3 | 40.3 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 7,195.5 | 9,632.7 | 2,437.2 |
| Үндсэн хөрөнгө | 33,348.4 | 35,542.2 | 2,193.8 |
| **Нийт хөрөнгө** | **41,212.9** | **45,884.2** | **4,671.3** |
| Өр төлбөр | 215.3 | - | (215,3) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 40,997.6 | 45,884.2 | 4,886.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **41,212.9** | **45,884.2** | **4,671.3** |

Авлагын эхний үлдэгдлийн 669.0 мянган төгрөгийг бүрэн барагдуулж тайлант онд 6 байгууллага 1 иргэний нийт 709.3 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,632.7 мянган төгрөг болж 2,437.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 10,696.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 1,097.0 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 8,536.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж 820.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг акталж устгаснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр /* 126,190.1 мянган төгрөг болж 7,350.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4 ширхэг зөөврийн компьютер худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 45,884.2 мянган төгрөг болж 4,886.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 26,714.0 мянган төгрөгөөр буюу 14.0 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан үнэт цаас 317.0 мянган төгрөгөөр, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс олгосон санхүүжилт

460.0 мянган төгрөгөөр, улсын төсвөөс олгосон санхүүжилт 30,708.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Тайлант оны нийт зардал өмнөх оноос 17,039.8 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон хангамж, бараа материалын зардал нийт 3,871.6 мянган төгрөгөөр буурч , тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 20,911.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 287,469.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 85,687.0 мянган төгрөгөөр бууруулж, **201,782.5** мянган төгрөгөөр батлагдсан байна.

Энэ нь цалин, НДШ-ийн зардал 49,458.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 12,010.7 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 5,991.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж 15,575.9 мянган төгрөгөөр, багаж,техник хэрэглэлийн зардал 2,650.0 мянган төгрөгөөр тус тус буурч батлагдсантай холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 130,302.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, өөрийн орлогоос 70,000.0 мянган төгрөгийн зэрэг нийт 200,302.5 мянган төгрөгийн төсөв баталж, санхүүжүүлэхээр төлөвлөжээ

2021 оны 12 дугаар сард батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж, өөрийн орлогоос 1,480.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн **201.782.5 мянган** төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 130,302.5 мянган төгрөгийн, өөрийн орлогоос 71,480.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, нийт 201,782.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төлбөртэй үйлчилгээний 75,901.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс 71,480.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж 4,421.8 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **200,322.3** мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 2.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,022.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 214.4 мянган төгрөгөөр, улсын мэдээллийн маягт хэвлүүлэх зардал 51.9 мянган төгрөгөөр,хог хаягдал зайлуулах зардал 168.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдэж, оны эцэст улсын төсвөөс авсан санхүүжилтээс 1,460.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130009001 тоот дансанд аймгийн Засаг даргын 2021 оны 10 сарын 11-ний өдрийн А/312 дугаар захирамжаар 460.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, "Чанарыг эрхэмлэх нь" гар зургийн уралдааны шагналд 350.0 мянган төгрөгийг, өргөмжлөл бичиг хэргийн зардалд 110.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т *"Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг* ***улсын төсөвт үйлдвэрийн газар*** *гэнэ"*, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 3.1-д *"Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно"* 3.1.4: *"Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа"* гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хэмжилзүйн техникч, жолооч Б.Хишигбаярын Сэлэнгэ аймаг дахь Тээврийг удирдах газарт сантехникч, жолоочоор ажиллаж байсан 6 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор Стандарт хэмжилзүйн газраас хянаж ирүүлсний дагуу нийт 20,911.4 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Тээврийн удирдах газар нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

### 3.8 Аудитын гол асуудал

2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 19 мэдээллийг хугацаа хоцроож, 130 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Стандарт, хэмжилзүйн хэлтсийн тайлант оны үйл ажиллагаанд 201,782.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 200,322.2 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.7 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: "*.....батлагдсан төсөвт зардлын дунд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх оны албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 834.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөгдсөнийг бүрэн биелүүлж , шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмжийг биелүүлээгүй байна.

*Хүснэгт 2.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Албан шаардлага | 1 | 834.3 | 1 | 834.3 | 100 |
| Зөвлөмж | 1 | | - | | - |
| **Нийт дүн** | **2** | **834.3** | **1** | **834.3** | **50,0** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,844.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1 албан шаардлага хүргүүлж, дараах алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгсөн.

**Зөвлөмж :**

### *4.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал*

*1.1 Илрүүлэлт:* Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс төлөвлөгөөт сургалтын зардалд 1,136.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас санхүүжүүлсэн байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:* Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

### *4.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал*

*2.1 Илрүүлэлт:* Тайлант онд 7,708.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь *"Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй"* гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо*

*хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ"* гэж заасныг зөрчсөн ба *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 *Өгсөн зөвлөмж:* Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Стандарт, хэмжилзүйн хэлтэс | 3 | 8,844.3 | | | | | 1 | - | 2 | 8,844.3 |